

ЗАРЛАЛ

**2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 01-НЫ ӨДРӨӨС 2023 ОНЫ 07
ДУГААР САРЫН 01-НЫ ӨДӨР ХҮРТЭЛХ ХУГАЦААНД ХОРШОOG
ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛД ХАМРАГДАХ
ХҮСЭЛТЭЙ ХОРШОО, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭГЧ ААН, ИРГЭДЭЭС *ТӨСӨЛ* ХҮЛЭЭН АВНА.
Төсөл нь сумын тэргүүлэх чиглэлд багтсан байхыг анхаарна уу.**

БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023.06.02

ЖУРМЫН ДАГУУ ТӨСӨЛД ХАВСАРГАХ МАТЕРИАЛ:

1. зээл хүссэн өргөдөл
2. төслийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалд хамрагдах тооцоо
3. хөрөнгө оруулалтын тооцоо (өөрийн хөрөнгө оруулалтын хэмжээ, зээлийн зарцуулалтын тооцоо)
4. төслийн өгөөж, хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа
5. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, шаардлагатай бүтсгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
6. хуулийн этгээдийн хаягийн тодорхойлолт, үүсгэн байгуулагчийн дэлгэрэнгүй лавлагаа
7. барьцаалах үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн болон эзэмших эрхийн у. бүртгэлийн гэрчилгээ, газрын гэрээ, кадастрын зургийн хуулбар
8. хэрэв зээлийн хэвийн үлдэгдэлтэй бол зээлийн гэрээ, зээлийн дансны баталгаажсан хуулга, зээлийн эргэн төлөлтийн хуваарийн хуулбар
9. сүүлийн 3 жилийн санхүүгийн баталгаажсан тайлан
10. жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлсэн тухай тухайн жилийн тодорхойлолт
11. нийгмийн даатгалын байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт
12. төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдээгүй талаар шүүхийн шийдвэр гүйц байгууллагын тодорхойлолт
13. төлсөн татварын хэмжээ болон татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тал харьяа татварын албаны тодорхойлолт
14. тухайн төсөл болон төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээллийг олон нийти хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг зөвшөөрснийг илэрхийлсэн мэд:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн
07 дугаар тогтоолын 01 дугээр хавсралт

"Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн телүүлэх, хяналт тавих журам"-ын З.2.1-т заасны дагуу сумын жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл

1. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр
 - Тэмс, хүнсний ногоо тариалалт
 - Хүлэмжийн аж ахуй
 - Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
 - Нийтийн хоол үйлдвэрлэл
 - Талх, нарийн боовны үйлдвэрлэл
 - Арьс, ширэн эдлэл боловсруулах үйлдвэрлэл
 - Гахай, тахианы аж ахуй
 - Мах, сүүний чиглэлээр эрчимжсэн фермерийн аж ахуй
 - Жимс, жимсгэнэ тариалах, мод үржүүлэх
 - Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
 - Мал аж ахуйн гаралтай Түүхий эд хүлээн авах, борлуулах нэгдсэн цэг байгуулах, өргөтгөх
 - Цагаан идээ борлуулах нэгдсэн цэг байгуулах
2. Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр
 - Оёдол, нэхмэл, сүлжмэлийн үйлдвэр
 - Мод, модон здлэл
 - Хоёрдогч түүхий эд хүлээн авах, борлуулах цэг байгуулах
 - Сав баглаа боодол үйлдвэрлэл
3. Нийтийн ахуй үйлчилгээний чиглэлээр
 - Халуун ус, саун
 - Усчин
 - Зурагчин
 - Зочид буудлын үйлчилгээ
4. Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр
 - Блок, тоосго үйлдвэрлэл
 - Зам талбайн хавтан, хашлага, хашаа үйлдвэрлэл
5. Авто машин засвар
 - Авто засвар
 - Автомашины угаалгын газар